

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20..оны ...дугаар
сарын ...өдөр

Улаанбаатар хот

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ
ТУХАЙ ХУУЛЬ**

/Шинэчилсэн найруулга/

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл.Хуулийн зорилго**

1.1.Энэ хуулийн зорилго нь Монгол Улсаас гадаад улсад, эсхүл гадаад улсаас Монгол Улс руу чиглэсэн ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний харилцаанд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шилжилт хөдөлгөөний удирдлага, зохион байгуулалтыг үндэсний хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэлд тулгуурлан, нэгдмэл байдлаар зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль тогтоомж

2.1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль², Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль³, Зөрчлийн тухай хууль⁴, Монгол Улсын хилийн тухай хууль⁵, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль⁶ Хөдөлмөрийн тухай хууль⁷, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль⁸, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль дараах харилцаанд үйлчилнэ:

3.1.1.Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлүүлэх, үйлдвэрлэлд дадлагажуулах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, эх орондоо эргэн ирэхийг дэмжихтэй холбогдсон харилцаа;

3.1.2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх, үйлдвэрлэлд дадлагажуулах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон харилцаа;

¹ Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

³ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2010 оны 32 дүгээрт нийтлэгдсэн.

⁴ Зөрчлийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 24 дүгээрт нийтлэгдсэн.

⁵ Монгол Улсын хилийн тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2017 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль энэ хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1994 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Хөдөлмөрийн тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль- “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2011 оны 39 дүгээрт нийтлэгдсэн.

3.2.Энэ хууль Дипломат төлөөлөгчийн газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн болон бусад эрх бүхий олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын дипломат ажилтны дархан эрх, эрх ямба эдлэхтэй холбоотой харилцаанд үйлчлэхгүй.

3.3.Энэ хууль Монгол Улсын ажиллах хүчний дотоод шилжилт хөдөлгөөнтэй холбоотой харилцаанд үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг зохицуулахад баримтлах зарчим

4.1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнийг удирдах, зохицуулахад дараах тусгай зарчмыг баримтална:

4.1.1.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд тулгуурлах;

4.1.2.үндэсний хүний нөөцийн чадавхийг дэмжих;

4.1.3.нэгдмэл, ил тод, уян хатан, шуурхай, цогц байдлаар удирдан, зохион байгуулах.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“гадаадад ажилтан нийлүүлэх гэрээ” гэж Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлүүлэх, үйлдвэрлэлд дадлагажуулах нөхцөлийн талаар хүлээн авагч болон илгээгч талын эрх бүхий байгууллага хооронд бичгээр байгуулсан хэлцлийг;

5.1.2.“зуучлах үйлчилгээ” гэж Монгол Улсын иргэнийг гадаад улсад, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, эсхүл үйлдвэрлэлд дадлагажихад зуучлах, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг;

5.1.3.“зуучлагч” гэж зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний харилцаанд бие даан оролцох ашгийн төлөө хуулийн этгээдийг;

5.1.4.“зуучлуулагч” гэж зуучлах үйлчилгээ авч буй Монгол Улсын иргэн болон гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

5.1.5.“гадаад ажилтан” гэж Монгол Улсад хөдөлмөр эрхэлж, эсхүл үйлдвэрлэлд дадлагажиж байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

5.1.6.“монгол ажилтан” гэж энэ хуулийн 5.1.1-д заасан гэрээний дагуу гадаад улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэлд дадлагажиж, эсхүл хөдөлмөр эрхэлж буй Монгол Улсын иргэнийг;

5.1.7.“хууль бус хөдөлмөр эрхлэлт” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд тодорхойлсон хөдөлмөрийн харилцаанд оролцож, ашиг, орлого олох зорилготой эсэхээс үл хамааран, энэ хуульд заасан зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр ажил гүйцэтгүүлсэн, хөлсөөр ажиллуулсан, туслан гүйцэтгүүлсэн бүх төрлийн хөдөлмөр эрхлэлт, тэдгээрийг хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан, элсүүлсэн, тээвэрлэсэн үйлдлийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ
МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙГ ГАДААД УЛСАД
ХӨДӨЛМӨР ЭРХЛҮҮЛЭХ

6 дугаар зүйл. Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ

6.1. Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлд дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх/-ийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага олгоно.

Тайлбар: Үйлдвэрлэлд дадлагажих гэж ажлын байрны үндсэн чиг үүргийг сургалт, зааварчилгаатайгаар сургагч - ажилтныг дагалдуулан, цалин хөлстэй гүйцэтгэх хөдөлмөр эрхлэлтийг ойлгоно.

6.2. Зуучлах үйлчилгээг дараах этгээд эрхлэхийг хориглоно.

6.2.1. аялал жуулчлал, агаарын тээврийн тасалбарын үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээд;

6.2.2. гадаад улсад ажилтан илгээхэд хууран мэхлэх, төөрөгдүүлэх, залилах, бусад аргаар зөрчил, гэмт хэрэг үйлдсэн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон хүн, хуулийн этгээд;

6.2.3. гадаад улсад ажилтан илгээх асуудал хариуцсан бүх шатны байгууллагын төрийн албан хаагч;

6.2.4. гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд;

6.2.5. тусгай зөвшөөрөлгүй этгээд;

6.2.6. гадаадын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын хуулийн этгээд;

6.2.7. төрийн бус байгууллага;

6.2.8. хууль тогтоомжид заасан бусад.

6.3. Гадаад улсад ажилтан зуучлах үйлчилгээ үзүүлэх журам, холбогдох гэрээний загварыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, бүрдүүлэх баримт бичиг

7.1. Тусгай зөвшөөрлийг дараах нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд олгоно:

7.1.1. гадаадад ажилтан нийлүүлэх хүчин төгөлдөр гэрээтэй байх;

7.1.2. хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн гишүүн, үүсгэн байгуулагч, удирдах болон гүйцэтгэх ажилтан нь хүн худалдаалах, өмчлөх эрхийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйлд заасан зөрчил үйлдэж байгаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй байх;

7.1.3. хуулийн этгээд нь хүн худалдаалах, өмчлөх эрхийн эсрэг болон эдийн засгийн гэмт хэрэг, Зөрчлийн тухай хуулийн 10.13 дугаар зүйлд заасан зөрчил үйлдээгүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй байх;

7.1.4.зуучлах үйлчилгээ эрхлэх орон тооны ажилтантай байх;

7.1.5.Хуулийн этгээдийн өөрийн хөрөнгийн хэмжээ 100.000.000 төгрөгөөс доошгүй байх.

7.2. Хүсэлт гаргагч энэ хуулийн 8.1-т заасан урьдчилсан баталгаа авахдаа дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

7.2.1.хуулийн этгээдийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, хүний нөөцийн мэдээлэл /танилцуулга болон энэ хуулийн 7.1.2 заасан шаардлага хангаж буй талаарх/;

7.2.2. хуулийн этгээдийн удирдах зөвлөл, үүсгэн байгуулагчдын мэдээлэл;

7.2.3.санхүүгийн эх үүсвэр, түүний баталгаа, санхүүгийн аудитаар баталгаажсан тайлангийн хуулбар;

7.2.4.шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй тухай баримт;

7.2.5.зуучлуулагчид хохирол учруулсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх тухай төлөөлөн удирдах зөвлөл болон бүх шатны удирдлагын баталгаа /нотариатаар баталгаажуулсан байх/;

7.2.6. зуучлуулагчийг бүртгэх, сонгон шалгаруулах журам;

7.2.7.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм;

7.2.8.хууль тогтоомжид заасан бусад.

7.3.Урьдчилсан баталгаа эзэмшигч баталгааны хүчинтэй хугацаа дуусахаас гурваас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл эзэмших хүсэлтийг дараах баримт бичгийн хамт хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

7.3.1.гадаадад ажилтан нийлүүлэх гэрээ;

7.3.2.эрсдлийн санд хураамж байршуулсан баталгаа;

7.3.3.улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

7.3.4.энэ хуулийн 7.2-т заасан нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох мэдээлэл.

8 дугаар зүйл.Урьдчилсан баталгаа

8.1.Монгол Улсын иргэнийг гадаад улсад зуучлах үйлчилгээ эрхлэхэд гадаадад ажилтан нийлүүлэх гэрээнээс бусад зуучлах үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд урьдчилсан баталгааг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр олгоно.

8.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд урьдчилсан баталгаа олгоход мэргэжлийн дүгнэлт, зөвлөгөө өгөх орон тооны бус байнгын зөвлөл ажиллана. Зөвлөлийн бүрэлдэхүүн, урамшууллын хэмжээ, ажиллах журмыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.3.Зөвлөл энэ хуулийн 7.2-т заасан бичиг баримтыг үндэслэн хуулийн этгээдэд урьдчилсан баталгаа олгох эсэх асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргана.

8.4. Урьдчилсан баталгааны хүчинтэй хугацаа нэг жил байна.

9 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

9.1. Энэ хуулийн 7.2, 7.3-т заасны дагуу өргөдөл хүлээн авснаас хойш Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12.1-д заасан хугацаанд тусгай зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх бөгөөд хянан магадлах шаардлагатай тохиолдолд хугацааг ажлын 10 хүртэл хоногоор сунгаж болно.

9.2. Тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгоно.

9.3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ нь ялгагдах онцлог тэмдэг, улсын нэгдсэн дугаар, тухайн хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, ажиллах хүч авах улсын нэр, ажилтан илгээх хэлбэр, зуучлах зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа болон сунгалтыг заасан үнэт цаасан дээр хэвлэсэн баримт бичиг байна.

9.4. Ажиллах хүч хүлээн авах улсын хууль тогтоомж, эдийн засаг, нийгмийн байдлыг харгалзан хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зуучлагчийн тоонд хязгаар тогтоож болно. Тогтоосон тооны хязгаарт багтаан тусгай зөвшөөрлийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр энэ хуулийн 7.1-д заасан шаардлагыг бүрэн хангасан хуулийн этгээдээс эхэлж бүртгүүлсэн дарааллаар тусгай зөвшөөрлийг олгоно.

9.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрөлд зааснаас өөр улсад зуучлах үйлчилгээ эрхлэх бол ажилтан нийлүүлэх улстай хийсэн гэрээ, уг гэрээг хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан тухай баримт бичгийг бүрдүүлэн, тусгай зөвшөөрөл авах тухай хүсэлтийг энэ хуульд заасан журмын дагуу гаргана.

9.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрөл авсны дараа гадаадад ажилтан нийлүүлэх гэрээ, гадаад улсад ажиллах иргэнийг сонгон шалгаруулах журамд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 хоногийн дотор хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тухай бүр мэдэгдэж, бүртгүүлнэ.

9.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд, зуучлалын үйлчилгээ хариуцсан ажилтан, хувь нийлүүлэгч, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, байгууллагын хаяг, байршил, харилцах утас, факс, шуудангийн хаяг өөрчлөгдсөнийг тухай бүр ажлын 5 хоногт багтаан, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

9.8. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэрийг гарсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор улсын бүртгэлийн, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн хяналтын, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар болон хүлээн авагч улсын холбогдох байгууллагад хүргүүлж, өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах

10.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацаа сунгуулах өргөдөл /хүлээн авагч улс, ажил олгогч, үйл ажиллагааны чиглэл, салбар, хугацааг тодорхой дурдах/-ийг дараах бичиг баримтын хамт тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусахаас ажлын 20-оос доошгүй хоногийн өмнө хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

10.1.1.гадаадад ажилтан нийлүүлэх гэрээ хүчинтэй талаарх баримт;

10.1.2.санхүүгийн аудитын тайлан /шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөрийн өргүй байх/;

10.1.3.тусгай зөвшөөрлийн хугацаанд хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн талаарх ажлын тайлан.

10.2.Тусгай зөвшөөрлийг гадаадад ажилтан нийлүүлэх гэрээний хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүн, хууль тогтоомжийн биелэлтийг харгалзан 3 жилийн хугацаагаар сунгана.

10.3. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх асуудлыг тухайн тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааны дотор шийдвэрлэнэ.

10.4.Хүндэтгэх үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 10.1-т заасан хугацаанаас хоцорч гаргасан хүсэлтийг хүлээн авахгүй бөгөөд тусгай зөвшөөрлийг дуусгавар болсонд тооцно.

11 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

11.1.Тусгай зөвшөөрлийг дараах тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

11.1.1.тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

11.1.2.зуучлах үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

11.1.3.зургаан сарын хугацаанд тайлан ирүүлээгүй, эсхүл нэг жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй;

11.1.4.иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироосон талаар хөдөлмөр эрхлэлтийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргасан.

11.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 11.1-д заасан нөхцөл байдал үүссэн даруйд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигчид үүссэн нөхцөл байдлыг арилгуулах талаар нэг сар хүртэл хугацаатай мэдэгдэл хүргүүлнэ.

11.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор тайлбар, зөрчлийг арилгасан талаарх холбогдох нотлох баримтыг ирүүлнэ.

11.4.Тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уг зөвшөөрлийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сэргээнэ.

11.5.Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэнтэй холбоотой зуучлуулагчид үүсэх эрх зүйн үр дагаврыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцна.

12 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

12.1.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-т зааснаас гадна дараах үндэслэлээр тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

12.1.1.гадаад улсад ажилтан нийлүүлэх гэрээ дуусгавар болж, зөвшөөрлийн хугацаанд сунгагдаагүй;

12.1.2.энэ хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан;

12.1.3.тусгай зөвшөөрөл олгосон шийдвэр нь хууль бус болохыг эрх бүхий байгууллагаас тогтоосон;

12.1.4.тусгай зөвшөөрөл олгосноос хойш 1 жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаа нь зогссон;

12.1.5.энэ хуулийн 10.1-т заасан хугацаанд тусгай зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргаагүй, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон;

12.1.6.хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр тусгай зөвшөөрлийг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн;

12.1.7.хууль тогтоомж, зуучлах үйлчилгээ үзүүлэх журам зөрчиж зуучлуулагчид хохирол учруулсан, хууран мэхэлсэн, хууль бусаар төлбөр хураамж авсан нь тогтоогдсон, хууль, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс зуучлуулагчид хохирол учруулсан;

12.1.8.гадаадад ажиллаж буй монгол ажилтанд туслахаас үндэслэлгүйгээр татгалзсан, гэрээнд заасан зуучлуулагчийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

12.1.9.химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодистой харьцах, хар тамхи, мансууруулах бодис үйлдвэрлэх, борлуулах зэрэг олон улсын хэмжээнд хориглосон, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй ажлын байранд иргэдийг зуучилсан;

12.1.10.Тусгай зөвшөөрлийн үйлчлэлийг түдгэлзүүлсэн нөхцөлийг арилгаагүй, эсхүл тайлбар, нотлох баримт ирүүлээгүй.

13 дугаар зүйл.Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлд дадлагажихад зуучлагчийн эрх, үүрэг

13.1.Зуучлагч нь дараах эрхтэй:

13.1.1.зуучлах үйлчилгээ эрхлэхтэй холбоотой мэдээ, мэдээллийг холбогдох төрийн байгууллагаас авах;

13.1.2.зуучлуулагчтай зуучлалын гэрээ байгуулах;

13.1.3.гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотой зуучлуулагчид шаардлага тавих;

13.1.4.эрсдлийн сангийн нөөц хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар мэдээлэл авах;

13.1.5.зуучлуулагчаас хууль тогтоомж, гэрээгээр зөвшөөрсөн төлбөр хураамж авах.

13.2.Зуучлагч нь дараах үүрэгтэй:

13.2.1.илгээгч болон хүлээн авагч улсын холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, зуучлалын гэрээний талаар зуучлуулагчийг мэдээллээр бүрэн хангах, баталгаажуулах;

13.2.2.зуучлалын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, холбогдох гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

13.2.3.зуучлалын үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгуулагад тайлагнах;

13.2.4.зуучлуулагчийн саналыг хөдөлмөрийн гэрээнд тусгуулах, гадаадад ажилтан нийлүүлэх гэрээгээр тохиролцсон хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг сайжруулах талаар ажил олгогч, хүлээн авагч талтай хэлэлцээ хийх;

13.2.5.эрсдлийн санд зохих журмын дагуу хөрөнгө байршуулах;

13.2.6.тусгай зөвшөөрөл хүчингүй, эсхүл хугацаа нь дуусгавар болсон бол гадаад ажил олгогчтой байгуулсан гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд зуучлалын гэрээний хэрэгжилтийг хангуулах;

13.2.7.зуучлалын гэрээ дуусгавар болсон даруйд зуучлуулагчийг эх оронд нь буцаан ирүүлэх, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж, мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох бусад байгуулагад хүргүүлэх;

13.2.8.гадаад улсад хөдөлмөр эрхлэх ажилтныг сонгон шалгаруулах журам баталж, мөрдүүлэх, зуучлуулагчид урьдчилж танилцуулж, мэдээлэх;

13.2.9.хуульд заасан бусад.

13.3.Ажлын байрны захиалгыг хүлээн авагч улсаас баталгаажуулах хүртэл зуучлуулагчаас 15.1.2-т зааснаас бусад аливаа төлбөр, хураамж авахыг хориглоно.

14 дүгээр зүйл.Гадаад улсад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлд дадлагажих зуучлуулагчийн эрх, үүрэг

14.1.Зуучлуулагч дараах эрхтэй:

14.1.1.хоёр улсын холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, зуучлалын гэрээний талаар мэдээ, мэдээлэл зуучлагчаас авах;

14.1.2.зуучлалын үйлчилгээний явцад гарсан маргаан, саналыг холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;

14.1.3.хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг сайжруулах талаар санал гаргах;

14.1.4.гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотой зуучлагчид шаардлага тавих;

14.1.5.эрсдлийн нөхцөл үүссэн тохиолдолд нөхөн төлбөр авах;

14.1.6.гадаад улсад эзэмшсэн ур чадвар, мэргэшлийн түвшинг үнэлүүлж, баримт бичиг авах.

14.2.Зуучлуулагч дараах үүрэг хүлээнэ:

14.2.1.зуучлалын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

14.2.2.бичиг баримтыг үнэн зөв бүрдүүлэх, зуучлагчийг үнэн зөв мэдээллээр хангах;

14.2.3.энэ хуулийн 15.1-д заасан шууд зардлыг хариуцах;

14.2.4.эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдах;

14.2.5.хууль тогтоомжид заасан бусад.

15 дугаар зүйл.Зуучлах үйлчилгээний зардал

15.1.Гадаадад ажилтан нийлүүлэх гэрээгээр тохиролцсон хүлээн авагч тал буюу ажил олгогч хариуцахаас бусад тохиолдолд зуучлуулагч дараах шууд зардлыг хариуцна:

15.1.1.тээврийн зардал;

15.1.2.бэлтгэл сургалтын зардал;

15.1.3.эрүүл мэндийн үзлэгийн зардал;

15.1.4.гадаад улсын виз мэдүүлэхтэй холбоотой зардал.

15.1.5.зуучлалын хураамж.

15.2.Зуучлалын хураамжийн хэмжээ нь тухайн хүлээн авагч улсын нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй байна.

15.3.Энэ хуульд зааснаас бусад төлбөр, хураамж, зардал, барьцааг аливаа хэлбэрээр зуучлуулагчаас авахыг хориглоно.

16 дугаар зүйл.Төрийн байгууллагаар дамжуулан зуучлах

16.1.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаадын эрх бүхий байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн хүрээнд ажилтан илгээх тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон төрийн байгууллага илгээх үйл ажиллагааг хариуцаж болно.

16.2.3000-аас дээш Монгол Улсын иргэн ажиллаж, амьдарч буй гадаад улсад төлөөлөгчийн газрыг байгуулан, ажиллуулж болно.

16.3. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллежид суралцагчдыг мэргэжлийн чиглэлээр гадаад улсад үйлдвэрлэлийн дадлагад хамруулах ажиллагааг тухайн төв, коллеж хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийн үндсэн дээр хариуцаж болно.

17 дугаар зүйл.Гадаад улсад хөдөлмөр эрхлэхийн өмнөх бэлтгэх сургалт

17.1.Гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд бэлтгэх сургалт нь дараах агуулгатай байна:

17.1.1.хүлээн авагч улсын талаарх мэдээлэл /илгээгч болон хүлээн авагч улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, хамтын гэрээ хэлэлцээр, соёл, зан заншил, улс төр, нийгэм, эдийн засгийн байдал, хэл, нийтлэг анхаарах зүйлс/;

17.1.2.хүлээн авагч улсын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, санал болгож буй ажлын байр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эвлэлдэн нэгдэх боломж, үйлдвэрчний болон төрийн бус байгууллагын талаар мэдээлэл;

17.1.3.эрүүл мэнд, нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын арга хэмжээ;

17.1.4.болзошгүй эрсдэл, түүнээс хамгаалах арга хэмжээ, эрсдлийн сангийн мэдээлэл;

17.1.5.зуучлуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;

17.1.6.шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллага;

17.1.7.буцаж ирсний дараа Монгол Улсад хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ;

17.1.8.холбогдох бусад мэдээлэл.

17.2.Сургалтын хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

17.3.Сургалтыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд зохион байгуулах бөгөөд хэрэгжилтэд хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

18 дугаар зүйл.Монгол ажилтныг буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх

18.1.Дипломат төлөөлөгчийн газар нь гадаад улсад хөдөлмөр эрхэлж буй иргэний хөдөлмөрлөх эрхийг хангах чиглэлээр дараах үүрэгтэй:

18.1.1.хүлээн авагч улсын хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээ авахтай холбогдох асуудлаар мэдээлэл түгээх;

18.1.2.хүлээн авагч улсад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай тохиолдолд хамгаалалтад авах, аюулгүй байдлыг хангуулах, холбогдох байгууллагад хандах;

18.1.3.хүлээн авагч улсын хөдөлмөрийн гэрээний нөхцөл, болзол нь Монгол Улсын хөдөлмөрийн хууль, тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг нягтлах, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах;

18.1.4.гадаад ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээ зөрчигдсөн тохиолдолд ажилтанд хууль зүйн туслалцаа үзүүлэх;

18.1.5.тухайн улсад албан бусаар оршин сууж, хөдөлмөр эрхэлж байгаа Монгол иргэний тоог бууруулах, албан ёсны зөвшөөрөл олгуулах чиглэлээр хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

18.1.6.хүлээн авагч улсад хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэний талаар бүртгэл, мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр хүргүүлэх;

18.1.7.Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг сурталчилах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн улсад зохион байгуулах.

18.2.Тухайн гадаад улсад амьдарч буй Монгол иргэдийн холбоо, сан, түүнтэй адилтгах сайн дурын байгууллагатай энэ хуулийн 18.1, 21-д заасан үүргийг хэрэгжүүлэх, биелэлтийг үнэлэхэд хамтран ажиллана.

18.3.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаа

Монгол Улсын иргэний эх орондоо буцан ирж хөдөлмөр эрхлэхийг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөр батлуулж, хэрэгжилтийг хангана.

18.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлүүлсэн тухай мэдээллийг тогтоосон журмын дагуу хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

19 дүгээр зүйл.Зуучлуулагч ажилтны мэргэжил, ур чадварыг баталгаажуулах

19.1.Гадаадад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлд дадлагажихаар бүртгүүлсэн зуучлуулагчийн Монгол Улсад эзэмшсэн мэргэжил, ур чадварын гэрчилгээ, үнэмлэх, дипломыг хүлээн авагч улсаас шаардсан тохиолдолд холбогдох түвшний боловсролын асуудал хариуцсан төрийн байгууллага баталгаажуулна.

19.2.Эх орондоо буцан ирсэн Монгол ажилтан гадаад улсад эзэмшсэн мэргэжил, ур чадвараа хүлээн авагч улсдаа баталгаажуулаагүй тохиолдолд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн дагуу иргэний хүсэлтийн дагуу мэргэшил, ур чадварын түвшинг тогтооно.

20 дугаар зүйл.Монгол ажилтныг дэмжих

20.1.Гадаадад хөдөлмөр эрхлэгч, үйлдвэрлэлд дадлагажигч Монгол Улсын иргэнд эх орондоо буцан ирсэний дараа дараах дэмжлэг үзүүлнэ:

20.2.1.хууль тогтоомжид заасны дагуу дасан зохицох, ажлын байр бий болгох, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулах;

20.2.2.гадаадад эзэмшсэн мэргэшил, ур чадварын дагуу ноу-хау, техник технологийн чиглэлээр импортын тоног төхөөрөмж, бараа, материал оруулж ирэхэд нь хууль тогтоомжид заасны дагуу нэг удаа гаалийн татвар, бусад татварын хөнгөлөлт үзүүлэх;

20.3.Энэ хуулийн 20.2.1-д заасан үйл ажиллагааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

20.4.Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар гадаад улсад хөдөлмөр эрхлэгч, үйлдвэрлэлд дадлагажигч Монгол Улсын иргэнд дараах үйлчилгээ үзүүлнэ:

20.4.1.хүлээн авагч талын нутаг дэвсгэр дээр хууль зүйн туслалцаа үзүүлэх;

20.4.2.хүлээн авагч талын хөдөлмөрийн нөхцөл, соёл, ёс заншлын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөх;

20.4.3.ажил олгогч талаас хөдөлмөрийн гэрээг зөрчсөний улмаас эрх нь зөрчигдсөн, тусламж шаардлагатай иргэнд өөр ажлын байр олж шилжүүлэх, эсхүл эх оронд нь буцаах хүртэл түр хугацаанд шаардлагатай амьдрах орчны анхан шатны тусламж үзүүлэх.

20.5.Энэ хуулийн 20.4-д заасан үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.4.16-д заасан Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас санхүүжүүлнэ.

20.6.Энэ зүйлд заасан гадаадад хөдөлмөр эрхлэгч, үйлдвэрлэлд дадлагажигч гэдэгт энэ хуулийн 5.1.6-д зааснаас гадна гадаад улсад үйлдвэрлэлд дадлагажих буюу

хөдөлмөр эрхэлсэн, эсхүл дуусгасан эсэхээс үл хамааран сургалтын байгууллага, их дээд сургуульд суралцсан иргэнийг хамааруулна.

21 дүгээр зүйл.Гадаадад дахь монгол ажилтныг эрсдэлээс хамгаалах

21.1.Монгол Улсын иргэн гадаад улсад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлд дадлагажих хугацаанд болзошгүй эрсдлээс хамгаалах талаар энэ хуульд заасан арга хэмжээг Хилийн чандад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас санхүүжүүлнэ.

21.2. Хилийн чандад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас дараах зардлыг санхүүжүүлнэ:

21.2.1.ажилтнаас үл хамаарах шалтгаанаар ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг хугацаанаас өмнө цуцалсны хохирлыг барагдуулах;

21.2.2.амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг барагдуулах;

21.2.3.цалин хөлс олгогдоогүйгээс учирсан хохирлыг барагдуулах;

21.2.4.Онгой нөхцөл байдал үүссэн үеийн нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой зардал;

21.2.5.Хууль тогтоомжид заасан бусад.

21.3.Хилийн чандад байгаа Монгол Улсын иргэдэд туслах санд Монгол Улсын иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч гадаад улсад илгээсэн зуучлуулагч тутамд 100.000 төгрөгийн хураамж байршуулна.

21.4. Сангийн мэдээлэл нээлттэй, ил тод байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАДААД УЛСЫН ИРГЭНИЙГ МОНГОЛ УЛСАД ХӨДӨЛМӨР ЭРХЛҮҮЛЭХ

22 дүгээр зүйл.Гадаад ажилтны ажлын байрны ангилал, төрөл, түүнд тавигдах шаардлага

22.1.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны ажлын байр дараах ангилал, төрөлтэй байна.Үүнд:

Ажлын байрны ангилал	Ажлын байрны төрөл	Хөдөлмөр эрхлэх визийн төрөл
1.Өндөр зэрэглэлийн ур чадвар, мэргэжил бүхий удирдах түвшний байнгын ажлын байр	1.Гадаадын хөрөнгө оруулалттай ХХК-ний үүсгэн байгуулагч, гадаадын хөрөнгө оруулагч	HG 1-1
	2.Хувьцаат компанийн ТУЗ-ын гишүүн	HG 1-2
2.Өндөр зэрэглэлийн ур чадвартай, нарийн мэргэшсэн ажлын байр	1.Хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд үндэслэж, Монгол Улсын Засгийн газраас тодорхойлсон нарийн мэргэжлийн ажилтан	HG 2-1
	2.Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын гэрээнд тусгайлан заасны дагуу, зөвхөн тухайн гэрээний хугацаанд гадаад улсаас Монгол Улсад ажиллах нарийн мэргэжлийн инженер, техникийн мэргэжилтэн	HG 2-2

3.Засгийн газар хоорондын гэрээний дагуу төрийн байгууллагад дахь ажлын байр	1. Монгол Улсын олон улсын гэрээний дагуу ажиллах төрийн байгууллагад ажиллах ажилтан	HG 3
4.Олон улсын байгууллагын ажлын байр, сайн дурын ажилтан	1.Ашгийн төлөө болон, шашны үйл ажиллагаа эрхэлдэгээс бусад, зөвхөн хүмүүнлэгийн олон улсын хөдөлгөөн, хөтөлбөр, сангийн ажилтан, /үнэ төлбөргүй эрүүл мэндийн нарийн мэргэшлийн оношлогоо, зөвлөгөө, мэс засал хийх, эсхүл түүнтэй дүйцэх байнгын бус ажлын байр/	HG 4
5.Дунд зэрэглэлийн ур чадвар, ерөнхий мэргэжил бүхий байнгын ажлын байр	1.Магистрын зэрэг ба түүнээс дээш дээд боловсролын зэрэгтэй зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжилтэн, шинжлэх ухааны судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан, их, дээд сургуульд сургалт хийх, хичээл заах багш	HG 5-1
	2.Бакалаврын зэрэг ба түүнээс дээш дээд боловсролын зэрэгтэй, дипломтой ЕБС-ын сургууль, цэцэрлэг,сургалтын төвийн багш, ажилтан	HG 5-2
	3.Мэргэжлийн боловсрол эзэмшснийг нотлох тухайн улсын төрийн эрх бүхий байгууллагын, эсхүл Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдөх гэрчилгээ, диплом, мэргэжлийн үнэмлэхтэй ажилтан	HG 5-3
6.Монгол Улсад 6 хүртэл сар ажиллах, улирлын эсхүл түр хугацааны ажлын байр	1.Зургаа хүртэл сараар ажиллах улирлын чанартай ажил эрхлэх ажилтан,	HG 6-1
	2.Зургаа хүртэл сараар ажиллах техник, технологийн доголдлыг шийдвэрлэх, эсхүл түүнтэй дүйцэхүйц зорилготой мэргэшлийн өндөр ур чадвартай түр хугацааны ажилтан	HG 6-2
7.Үйлдвэрлэлийн дадлагажигч, оюутан	1.Үйлдвэрлэлд дадлагажигч	S-1
	2.Монгол Улсын их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехникийн коллежид суралцаж байгаа оюутан	S-2

Тайлбар: Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны ажлын байрны ангилал, төрөлд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 15.1.8, 15.1.6-д заасан хөдөлмөр эрхлэх визний төрлийг дэд ангиллаар олгоно.

23 дугаар зүйл.Гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох

23.1.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох гадаад ажилтны тоог эдийн засгийн салбар бүрээр өмнөх оны 10 дугаар сарын 01-ний дотор салбарын яамдын саналыг харгалзан хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналаар Засгийн газар тогтооно.

23.2.Монгол Улсад тухайн онд гадаадаас ажилтан авч ажиллуулсан ажлын байрны жагсаалт, тоог дараа оны нэгдүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулж, нийтэд мэдээллэнэ.

23.3.Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч нийт ажлын байрны гуравны нэгээс доошгүй хэмжээнд Монгол Улсын иргэнийг ажиллуулах үүрэгтэй.

23.4.Гамшигийн эрсдэл бий болсон тохиолдолд түүний хор уршгийг арилгахад шаардагдах ажилтныг дотоодоос хангах бололцоогүй нөхцөл үүссэн тохиолдолд онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газрын шийдвэрээр энэ хуулийн 23.1-д заасан тоо хэмжээг үл харгалзан, гадаад улсаас гамшигийн хор уршигийг арилгах хүртэл хугацаанд гадаад ажилтан авч болно.

23.5.Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гадаадаас ажилтан авсан ажил олгогчтой бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байранд дагалдуулан сургах, ажлын байраар хангах гэрээ байгуулж хэрэгжүүлнэ.

24 дүгээр зүйл.Гадаадаас ажилтан авч ажиллуулах зөвшөөрөл олгох

24.1.Ажил олгогч аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад хүний нөөцийн хэрэгцээ, тухайн сул ажлын байранд тавигдах шаардлагын талаарх мэдээллээ хүргүүлж, ажилтан авах хүсэлт гаргана.

24.2.Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд байршуулж, нэн даруй нийтэд мэдээлнэ.

24.3.Ажил олгогч гадаадаас ажилтан авах зорилгоор тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжил, ур чадварыг хэт өндөр тавих, ажлын байрны шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзахыг хориглоно. Энэ заалтын хэрэгжилтэнд тухайн аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, хөдөлмөрийн улсын байцаагч хяналт тавина.

24.4.Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн санд ажлын байрны зарыг байршуулж, ажилтныг идэвхтэй хайж эхэлснээс хойш 14 хоногийн дотор дотоодоос ажилтан авч чадаагүй бол гадаад улсаас ажилтан ажиллуулах зөвшөөрөл хүсэх эрхтэй.

24.5.Ажил олгогч гадаад улсаас ажилтан авч ажиллуулах хүсэлтийг дараах бичиг баримтын хамт хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гаргана:

24.5.1.гадаад ажилтан ажиллуулах ажлын байрны ангилал, төрөл, жагсаалт, байршил, тэдгээрийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон ажлын төлөвлөгөө;

24.5.2.улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх ажил, үйлчилгээнд хамаарах бол тусгай зөвшөөрлийн бичиг баримт;

24.5.3.гадаад ажилтны мэргэжил, ур чадварыг нотолсон баримт бичиг/тухайн улсын хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар баталгаажсан байх/;

24.5.4.энэ хуулийн 24.4 дэх шаардлагыг хангасан талаарх мэдээлэл, тодорхойлолт;

24.5.5.Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтоор баталгаажсан монгол ажилчдын тоо;

24.5.6.үйлчилгээний хураамж төлсөн тухай баримт;

24.5.7.хууль тогтоомжид заасан бусад.

24.6.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага шаардлага хангасан ажил олгогчид гадаад ажилтан авах зөвшөөрөл олгох бөгөөд зөвшөөрлийн хүчинтэй хугацаа 3 сар байна.

24.7.Энэ хуульд заасан хугацаанд гадаад ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл аваагүй нь хүндэтгэн үзэх шалтгаантай бол хугацааг нэг удаа 3 хүртэл сараар сунгаж болно.

24.8.Энэ хуулийн 22.1-ийн 5, 6 дахь хэсэгт заасан ажлын байрны ангилалд 24.5.3-т заасан мэргэжлийн зэрэглэл, ур чадварын үнэлгээг мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний асуудал хариуцсан байгууллага тогтоон баталгаажуулж, гэрчилгээжүүлж болно.

25 дугаар зүйл.Гадаад ажилтанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох

25.1.Энэ хуульд зааснаар зөвшөөрөл авсан ажил олгогч гадаадын ажилтныг сонгож, холбогдох баримт бичгийн хамт хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

25.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажил олгогчийн сонгосон гадаад ажиллах хүчний овог, нэр, иргэний харьяалал, хөдөлмөр эрхлүүлэх хуулийн этгээдийн нэр, хөдөлмөр эрхлэх байршил, зөвшөөрлийн хугацаа зэрэг мэдээлэл агуулсан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн үнэмлэх олгоно.

25.3.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаад ажиллах хүчинд виз, оршин суух зөвшөөрөл олгох асуудлыг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

25.4.Гадаад ажилтан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг ажлын байр, хөдөлмөрийн гэрээний хугацаанаас хамааруулан 1 жил хүртэл хугацаагаар олгоно.

25.5.Гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журмыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26 дугаар зүйл.Гадаад ажилтан авч ажиллуулах эрхийг хязгаарлах

26.1.Дараах ажил олгогчийн гадаад ажилтан авч ажиллуулах эрхийг 2 жилийн хугацаанд хязгаарлана:

26.1.1.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн;

26.1.2.өмнө нь хөдөлмөр эрхлүүлж байсан гадаад ажиллах хүчний цалин хөлсийг олгоогүй, эсхүл хохирол учруулсан нь тогтоогдсон;

26.1.3.энэ хуулийн 23.3, 24.3-т заасан үүргээ биелүүлээгүй, тайлан мэдээг хуурамчаар гаргасан нь тогтоогдсон.

27 дугаар зүйл. Ажил олгогчийн гадаад ажилтан авах зөвшөөрлийг цуцлах

27.1.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь дараах үндэслэлээр ажил олгогчийн гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрлийг цуцална:

27.1.1.зөвшөөрөл олгосон шийдвэр нь хууль бус болохыг эрх бүхий этгээд тогтоосон;

27.1.2.тухайн ажлыг гүйцэтгэхэд зохих мэргэжил, ур чадварын шаардлага хангасан Монгол Улсын иргэнийг хөдөлмөр эрхлүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан нь тогтоогдсон;

27.1.3.гадаад ажилтныг хилээр орж ирэхээс өмнө баталгаажуулсан хөдөлмөрийн гэрээгээр тохирсон цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөл, ажил амралтын горим зэрэг гэрээний нөхцөлийг хангаагүй, зөрчсөн;

27.1.4.ажил олгогч Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдож гадаад ажилтнаар Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх боломжгүй болсон;

27.1.5.гадаад ажилтныг хөдөлмөрт бэлтгэх сургалт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулаагүй;

27.1.6.хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, /гадаад ажилтныг зөвшөөрөл авснаас өөр зорилго, байршил, ажил үүрэг гүйцэтгүүлсэн/ зөвшөөрөл авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн /худал мэдээлэл өгсөн/ нь тогтоогдсон.

27.2.Гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлэх зөвшөөрөл нь цуцлагдсан ажил олгогчийн гадаад ажилтныг эрх бүхий өөр ажил олгогчид шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлэх эсэхийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нэн даруй шийдвэрлэнэ.

27.3.Гадаад ажилтныг эрх бүхий өөр ажил олгогчид шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлэх боломжгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд ажил олгогч нь 10 хоногийн дотор гадаад ажилтны хилээр гаргаж, энэ тухай хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

28 дугаар зүйл.Хууль бус хөдөлмөр эрхлэлтийг хориглох

28.1.Гадаадын иргэнийг зохих зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлүүлсэн ажил олгогчид Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28.2.Монгол Улсад хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэнийг эх оронд нь буцаах талаар улс хоорондын гэрээгээр, эсхүл Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэнэ.

29 дүгээр зүйл.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтныг бүртгэх

29.1.Ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад дараах шаардлага хангасан гадаад ажилтныг мэдээллийн санд бүртгүүлнэ:

29.1.1.эрүүл мэндийн үзлэгээр тэнцсэн;

29.1.2.Монгол Улсын хууль тогтоомжинд заасан хөдөлмөр эрхлэх насанд хүрсэн байх;

29.1.3.тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэргэжил эзэмшсэн;

29.1.4.хууль тогтоомжид заасан бусад.

29.2.Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журмыг эрүүл мэндийн болон хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

30 дугаар зүйл.Гадаадаас ажилтан авах зуучлах үйлчилгээ

30.1.Ажил олгогч нь гадаад ажилтан зуучлах үйлчилгээ эрхлэх эрх бүхий зуучлагчаар дамжуулан гадаад ажилтныг ажиллуулж болно.

30.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 7.1-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан хуулийн этгээдэд гадаадаас ажилтан зуучлах үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгоно.

30.3.Гадаадаас ажилтан зуучлах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, гадаад ажилтан зуучлах үйлчилгээ эрхлэх журмыг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

30.4.Гадаадаас ажилтан зуучлах зуучлагчийн үйл ажиллагаанд энэ хуульд заасан журам үйлчилнэ.

31 дүгээр зүйл.Гадаад ажилтны зөвшөөрлийн хугацааг сунгах

31.1.Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг ажил олгогчийн хүсэлт, ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны ангилал, цаашид ажиллуулах болсон үндэслэл шалтгаан, хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг үндэслэн сунгаж болно.

31.2.Гадаад ажилтан Монгол Улсад тасралтгүй хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн нийт хугацаа нь 5 жилээс ихгүй байна.

32 дугаар зүйл.Гадаад ажилтныг шилжүүлэн хөдөлмөр эрхлүүлэх

32.1.Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаад ажилтан дараах тохиолдолд өөр байгууллагад шилжин ажиллах хүсэлт гаргаж болно:

32.1.1.ажилтнаас үл хамаарах шалтгаанаар хөдөлмөрийн гэрээг цуцлах тухай мэдэгдэл авсан эсхүл хөдөлмөрийн гэрээний хугацаа дууссаны дараа гэрээг дахин сунгахгүй байх тухай мэдэгдэл авсан;

32.1.2.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаанаас өмнө гэрээт ажлаа хийж гүйцэтгэсэн, гэрээт ажил ажилтнаас шалтгаалалгүй зогссон, хуулийн этгээд татан буугдсан, ажил олгогч хөдөлмөрийн гэрээг зөрчиж цаашид үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэх боломжгүй болсон;

32.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гадаад ажилтанд анх олгосон зөвшөөрлийн хугацаанд багтаан хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоно.

32.3.Гадаад ажилтны шилжин ажиллах ажил олгогч нь энэ хуульд заасан шаардлагыг хангасан байна.

33 дугаар зүйл.Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

33.1.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

33.1.1.гадаад ажилтны буруугаас хөдөлмөрийн гэрээг цуцалсан, дуусгавар болсон нь хөдөлмөр эрхлэлтийн улсын байцаагчийн шийдвэрээр тогтоогдсон;

33.1.2.эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр тухайн ажлыг гүйцэтгэхэд эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон нь тогтоогдсон;

33.1.3.ажилтан хөдөлмөрийн чадвараа алдсан;

33.1.4.хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөр ажил олгогчид шилжиж ажилласан;

33.1.5.гадаад ажилтны мэдээллийн санд бүртгүүлэхдээ хуурамч баримт бичгээр бүртгүүлсэн;

33.1.6.зөрчилд холбогдож гэм буруутай болох нь тогтоогдсон;

33.1.7.ажилтан ажлын байраа дур мэдэн орхисон;

33.1.8.бусад.

33.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон, хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан тухай мэдээллийг гадаадын иргэн, харъяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

34 дүгээр зүйл.Гадаад ажилтныг хөдөлмөр эрхлэхэд чиг баримжаа олгох сургалтад хамруулах

34.1.Ажил олгогч анх удаа Монгол Улсад ирж буй гадаад ажилтныг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, ёс заншлын талаар ерөнхий мэдээлэл болон хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай тусгай мэдээллээр хангах хөдөлмөр эрхлэх чиг баримжаа олгох сургалтад хамруулна.

34.2.Гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлэхэд чиг баримжаа олгох сургалтын зардлыг ажил олгогч хариуцна.

34.3.Гадаад ажилтныг Монгол Улсад хөдөлмөр эрхлэхэд чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөрийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

35 дугаар зүйл.Гадаад ажилтны ажлын байрны төлбөр

35.1. Хуульд өөрөөр заагаагүй бол ажлын байрны төлбөрийн нэг сарын хэмжээ нь нэг сард ногдох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

Тайлбар: Ажлын байрны төлбөр гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ажил олгогч нь гадаад ажилтныг ажлын байраар хангаж, орлого бүхий хөдөлмөр эрхлүүлсний төлөө энэ хуульд заасан хэмжээгээр төлөх мөнгөн төлбөрийг ойлгоно.

35.2.Засгийн газар зарим салбарт ажиллах гадаад ажилтны төлбөрийг энэ хуулийн 22.1 дэх хэсгийн 1,2,3-т заасан ангилалын ажлын байранд 50 хувь бууруулж, 22.1 дэх хэсгийн 3,4,5-т заасан ангилалын ажлын байранд тухайн салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтооно.

35.3. Энэ хуулийн 22.1 дэх хэсгийн 7-д заасан ангиллын ажлын байр, Монгол Улсад ажиллах цагаач иргэнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлнө.

35.4. Ажил олгогч нь хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоогоор ажлын байрны төлбөрийг урьдчилан төлнө.

35.5. Ажил олгогч нь ажлын байрны төлбөр төлөх, буцаан авахтай холбоотой харилцааг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжоор зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ УДИРДЛАГА, МЭДЭЭЛЛИЙН САН

36 дугаар зүйл. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний харилцаанд оролцогч байгууллага хоорондын ажлын удирдлага, мэдээллийн сан

36.1. Ажиллах хүчний шилжих хөдөлгөөний бодлого, салбар дундын уялдааг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хангаж ажиллана.

37 дугаар зүйл. Монгол ажилтны мэдээллийн сан

37.1. Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гадаадад хөдөлмөр эрхлэгч, үйлдвэрлэлд дадлагажигч Монгол ажилтны мэдээллийн санг бүрдүүлнэ.

37.2. Мэдээллийн сан нь дараах мэдээллийг агуулсан байна:

37.2.1. ажилтны тоо, нас, хүйс;

37.2.2. ажлын байранд эзэмших ур чадвар, мэргэшил;

37.2.3. хөдөлмөрийн гэрээ, дуусгавар болох хугацаа;

37.2.4. шилжилт хөдөлгөөн;

37.2.5. гомдол, зөрчил;

37.2.6. зуучлагчийн мэдээлэл;

37.2.7. шаардлагатай гэж үзсэн бусад.

37.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг бүртгэж, мэдээлэх, тайлан, мэдээллийн маягыг Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.

37.4. Мэдээллийн сангийн бүрдэл, хөдөлгөөн, тогтмол шинэчилж байх асуудлыг хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцаж, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

37.5. Энэ хуульд заасан зуучлах үйлчилгээнд хамааралгүй, бие даан гадаад улсад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлд дадлагажиж буй Монгол Улсын иргэдийн мэдээллийг өөрсдийн хүсэлтээр мэдээллийн санд оруулна.

38 дугаар зүйл. Гадаад ажилтны мэдээллийн сан

38.1.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь гадаад ажилтны мэдээллийн санг бүрдүүлнэ.

38.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ажилтан илгээгч улсын эрх бүхий байгууллагатай тохиролцож мэдээллийн санг бүрдүүлнэ:

38.3. Мэдээллийн сан нь дараах мэдээллийг агуулсан байна:

- 38.3.1.ажилтны тоо, нас, хүйс;
- 38.3.2.мэргэжил, мэргэшил, ур чадварын мэдээлэл;
- 38.3.3.эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл;
- 38.3.4.ажиллах хүчийг илгээхийн өмнөх сургалтыг мэдээлэл;
- 38.3.5.шаардлагатай гэж үзсэн бусад.

38.4.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь зуучлах үйлчилгээгээр дамжуулаагүй Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилтны мэдээллийг санд оруулна.

39 дүгээр зүйл.Мэдээллийн сангийн ашиглалт

39.1.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хамтран ажиллах цахим мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээлэл харилцан солилцох журмыг Засгийн газар батална.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД

40 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

40.1.Энэ хуулийн хэрэгжилтэд Улсын Их Хурал, Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бүх шатны Засаг дарга, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, эрх бүхий улсын байцаагч, хууль тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан тус тусын чиг үүргийн хүрээнд хяналт тавина.

40.2.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас жилд нэгээс доошгүй удаа гадаад ажилтнаар хөдөлмөр эрхлүүлж байгаа ажил олгогчид зөвлөгөө өгөх, гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн нөхцөл, энэ хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ.

40.3.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь зөвлөгөө өгөх, хяналт шалгалт хийх удирдамж, чиглэлийг баталж, шалгалтаар илэрсэн зөрчлийг шийдвэрлэх, холбогдох байгууллагад мэдэгдэх арга хэмжээ авна.

41 дүгээр зүйл.Хөндлөнгийн хяналт

41.1. Энэ хуулийн 6,9,12,13,15,16,17, 18, 24, 26, 27, 30, 33, 34, 35 дугаар зүйлд заасан үйл ажиллагааны хуулийн хэрэгжилтэнд Төрийн бус байгууллага хяналт тавьж болно.

41.2.Хяналт тавих төрийн бус байгууллага нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3-т заасан шаардлагыг хангасан байна.

41.3.Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх хүсэлт гаргасан Төрийн бус байгууллагыг бүртгэж, хамтран ажиллана.

41.4.Хөндлөнгийн хяналт хэрэгжүүлсэн төрийн бус байгууллага нь Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлангаа тухай бүр хүргүүлнэ.

42 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

42.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан хаагчийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

42.3.Энэ хуулийг зөрчсөн үйлдлийн улмаас зуучлуулагч, гадаад ажилтанд хохирол учирсан бол Иргэний хуулийн дагуу хохирлыг нөхөн төлүүлнэ.

42.4.Хууль бусаар хөдөлмөр эрхэлсэн гадаадын иргэнд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

43 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

43.1.Энэ хуулийг 20..оныдүгээр сарын-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ